



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/390

Булган сум

Олон нийтийн эрүүл мэндийн ажилтныг  
чадавхжуулах сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.1.2.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны IV/03 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэнд" хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл амьдралын хэвшлийг эзэмшүүлэхээр ажилладаг олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардлагатай 570,000 (таван зуун далан мянга) төгрөгийг "Эрүүл мэнд" хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 29-ны/ний өдрийн 139 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫГ  
ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Сургалт зохион байгуулах газар: Булган аймгийн Засаг даргын Тамгын газар

Сургалт зохион байгуулах хугацаа: 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр 09:00 15:30 цагт

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
09:00-09:10	Бүртгэл	Ж.Гүндэгмаа, Булган аймгийн ЭМГ-ын мэргэжилтэн
09:10-09:40	Нээлтийн үйл ажиллагаа	М.Батчимэг, ЗДТГ-ын НБХ-ийн дарга П.Оюунцэцэг, ЭМГ С.Өнөрсайхан, НЭМҮТ-ийн захирал
09:40-10:20	"Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль"-ийн танилцуулга	С.Өнөрсайхан, НЭМҮТ-ийн захирал
10:20-11:00	Нийгмийн эрүүл мэндийн үндэс	С.Гэрэлмаа, ЭМДМА-ны дарга
11:00-11:30	Цайны завсарлага	
11:30-12:10	Сургалтыг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулах тухай	С.Гэрэлмаа, НЭМҮТ-ийн ЭМДМА-ны дарга
12:10-13:00	Эрүүл шүд аяны хэрэгжилт	Н.Хулан, ЭМГ-ын мэргэжилтэн
13:00-14:00	Цайны завсарлага	
14:00-14:30	Байгууллагын вэб, цахим хуудсаар мэдээлэл сурталчилгааг үр дүнтэй түгээх, зохион байгуулах	А.Сарантуяа, ЭМДМА-ны хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан
14:30-15:00	ХБӨ-ний анхдагч эрсдэлт хүчин зүйлс, эрүүл зан үйлийн тухай ойлголт	Б.Идшинхорлоо, ЭМДМА-ны мэргэжилтэн
15:00-15:30	Идэхтэй хөдөлгөөн ба сорил судалгаа	С.Гэрэлмаа, ЭМДМА-ны дарга
15:30-16:30	Эрүү мэнд хөтөлбөрийн хэрэгжилт	С.Гэрэлмаа, ЭМДМА-ны дарга
16:30-17:00	Өсвөр үе, залуучуудын эрүүл мэнд	С.Гэрэлмаа, ЭМДМА-ны дарга
17:00-17:30	Олон нийтийн ажилтан ажилтнуудыг чадавхжуулах нь	С.Өнөрсайхан, НЭМҮТ-ийн захирал
17:30-18:00	Эмийн зохистой хэрэглээ	Эм холбоо
18:00-18:20	Асуулт хариулт	Оролцогчид

Аймгийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 28-ны/ний өдрийн А/390 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

**АЖЛЫН БАЙРНЫ ДАДЛАГА СУРГАЛТЫН ТӨСӨВ**

д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1	2	3	4	4	5
1	Багш нарын урамшуулал	Хүн	3	190,000	570,000
	Дүн				<b>570,000</b>